


НИГЕРИ:

НАСУ АБДУЛАЗИЗ

ОРОН ГЭРГҮЙ БОЛСОН Ч ИТГЭЖ НАЙДСААР

ЭРХИЙНХЭЭ
ТӨЛӨӨ
БИЧИЦГЭЭЭ

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНИЛ



НАСУ АБДУЛАЗИЗ

НИГЕРИ

Хөл бөмбөгийн хорхойтон, Нигери залуучуудын хобби болсон дугуй унах дуртай Насу Абдулазиз яг одоо орон байртай байх эрхийнхээ төлөө тэмцэж байна. Нигерийн томоохон хотуудын нэг болох Лагос хотын Отодо Гбам омгийн оршин суугчид руу бульдозертой, зэвсэглэсэн этгээдүүд урьдчилан анхааруулж, мэдэгдэлгүйгээр халдсан юм. Энэ үед Насу 23 настай байв. Засгийн газрын тушаалыг биелүүлэх нэрээр эдгээр эрс олон зууны туршид оршин сууж ирсэн омгийнхны орон гэр, байшинг нурааж, шатаан, гэр бүлийнхнийг нь буудаж, ахуй амьдралыг нь сүйтгэжээ.

2017 онд, сүүлчийн нүүлгэн шилжүүлэлтийн өмнөх орой Насу руу танхай этгээд буудаж, гарыг нь гэмтээжээ. Маргааш нь Лагос хотын Шуурхай багийнхан тус омгийнхон руу дахин гал нээж, нулимс асгаруулагч хэрэглэсэн байна. Цочирдсон оршин суугчид зугтааж, зарим нь ойролцоох нуур руу үсэрч живсэн бөгөөд есөн хүн алагдаж, 15 хүн ор сураггүй болжээ.

Эцэст нь 30,000 хүн орон гэргүй болж, гүүрэн дор завин дээр амьдрах, эсвэл найз нөхдийндөө амьдрахаас өөр аргагүйд хүрчээ. Насу ч бас орон гэргүй болж, Нигерийн Албан бус суурьшлийн Холбоо буюу түүний нэгэн адил орон байртай байх эрхээ хангагдах хүртэл санаа амар байхыг хүсээгүй хүмүүсийн хөдөлгөөнд нэгдсэн юм.

НИГЕРИ УЛСЫН ЗРХ БАРИГЧ НАРТ ХАНДАН ЗАХИДАЛ БИЧИЦГЭЭЭ

Насу, түүний оршин сууж байсан нутгийнхныг албадан нүүлгэсэн хэргийг мөрдөн шалгаж, тэднийг дахин суурьшуулж, бүрэн нөхөн олговор олгосон эсэхийг баталгаажуулахыг шаардацгаая.

**H.E. Babajide Olusola
Sanwo-Olu,**
*Governor of Lagos State.
Governor's Office,
Ikeja
Lagos State
Email:
info@lagosstate.gov.ng
Twitter: @followlasg*

**НАСУД ЗВ САНААНЫ
НЭГДЛЭЭ ИЛЭРХИЙЛЭЭРЭЙ**
Түүнд орон байртай байх эрхийнхээ төлөө тэмцэхэд нь дэм болох итгэлийн зурвас, захидал илгээгээрэй.

**Amnesty International
Nigeria**
34, Colorado Street, Off
Alvan Ikoku Way, Maitama,
Abuja, FCT Nigeria

**ЗАХИДАЛ БИЧИЖ
ӨӨРЧЛӨЛТ ХИЙМЦГЭЭЭ**

December 2019
Index: AFR 44/0748/2019 English
Images: cover: © Amnesty International
(Main image), © Justice & Empowerment Initiatives Back page: © Justice & Empowerment Initiatives

